

НИЙМГИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2023 оны 09 дүгээр сарын 13

№01

Зүүнбаян-Улаан сум

Энэхүү гэрээг нэг талаас Зүүнбаян-Улаан сумын Засаг дарга Баттөмөр овогтой Баасан (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эм эс бэл майнинг” ХХК-ийн захирал ажилтай Базаррагчаа овогтой Тогооч (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2023 оны 9 дүгээр сарын 13 -ны өдөр Зүүнбаян-Улаан суманд байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээ нь Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын Өртөнт гэх газарт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах , уурхай ашиглах, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах , уурхай ашиглах, ажлын байр нэмэгдүүлэх талаар сайн дурын дэмжлэг үзүүлнэ.

1.3 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй тухайн сумын Засаг дарга гэрээ байгуулна.

Хоёр. Засаг даргын эрх, үүрэг

2.1 Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1 Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах,

2.1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн, ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах,

2.1.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих,

2.1.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх,

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1 Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1 Үйл ажиллагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлын талаар зохих журмын дагуу Засаг дарга, ИТХ-д тавьж шийдвэрлүүлэх,

3.1.2 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах,

3.1.3 Нийт ажлын байрны 30-аас доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах,

3.1.4 Өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг сумын Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх,

3.1.5 Бараа, ажил үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоотухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох,

3.1.6 Орон нутгийн малчин иргэдээс 10 үхэр, 1 тооно сүү, цагаан идээ худалдан авах,

3.1.7 Тусгай зөвшөөрөл бүхий 7 га газарт техникийн нөхөн сэргээлт хийх, техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн 5 га газарт биологийн нөхөн сэргээлт хийж, ногоон тэжээл тарьж, тухайн нутаг дэвсгэрт оршин суудаг нутгийн иргэдэд дэмжлэг хэлбэрээр олгох,

3.1.8 Сум орон нутагт өвөлжилтийн бэлтгэх ажлыг хангах ажлын хүрээнд 700 /долоон зуу/-н боодол өвч авч өгөх,

3.1.9 Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор авто машин авахад 14.000.000 /арван дөрвөн сая/ төгрөг шийдвэрлэж өгөх,

3.1.10 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах,

3.1.11 Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, хэрэгсэл, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх,

Дөрөв. Гэрээний хугацаа

4.1 Гэрээний хугацаа нь гэрээг хоёр тал баталгаажуулсан өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.

Тав. Хариуцлага

5.1 Гэрээ цуцалсан, дуусгавар болсонтой холбоотойгоор буруутай тал нөгөө талдаа учруулсан хохирол, гэм хор, зардлыг бүрэн хариуцаж арилгана.

Зургаа. Бусад зүйл


6.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

6.2 Гэрээнд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг талууд харилцан тохиролцож, бичгээр үйлдэн баталгаажуулна. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна. Гэрээний хавсралт №....., хуудас

6.3 Энэхүү гэрээнд тусгагдаагүй аливаа асуудлыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

6.4 Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба зөвшилцөлд эс хүрвэл Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.5 Энэхүү гэрээг монгол хэл дээр хоёр хувь үйлдсэн ба бүх хувиуд хуулийн адил хүчинтэй бөгөөд талуудад тус бүр нэг хувь хадгалагдана.



Засаг дарга:
Баттөмөр овогтой Баасан
Гарны үсэг:
Огноо: 2023.09.13
Хаяг: ЗБУ сум
Утас: 99144784

Гэрээ байгуулсан:

Тусгай зөвшөөрөл эзэмшигч:
Базаррагчаа овогтой Тогооч
Гарын үсэг:
Огноо: 2023.09.13
Хаяг: Арвайхээр сум
Утас: 89288252